

**ЗГХЭГ-ЫН САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН 2026 ОНЫ ЭХНИЙ
ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТАЙЛАНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ДҮН**

2026.06.19

Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний "Зорилго 4. Салбар болон орон нутгийн түвшинд бодлого зохицуулалтыг шинэ түвшинд хүргэнэ", "Зорилго 5. Орчин үеийн шаардлагад нийцсэн нийтлэг үйлчилгээний тогтолцоог бүрдүүлнэ" холбогдох 7 зорилтын хүрээнд Санхүү, хөрөнгө оруулалтын газраас 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 7 зорилтын хүрээнд 34 арга хэмжээ төлөвлөн хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Тус газрын гүйцэтгэлийн тайланг "Журам батлах тухай" Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам"-ын 2.4, 2.5-т заасан аргачлалаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Гүйцэтгэлийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ холбогдох аргачлалын дагуу батлагдсан төлөвлөгөөний шалгуур үзүүлэлт, суурь түвшин, зорилтот түвшинг тус тус харгалзан үзсэн.

Хүснэгт-1

№	Төлөвлөлтийн хэсэг	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	Гүйцэтгэлийн үнэлгээний дундаж хувь /өөрсдийн үнэлсэн/	ХШУДАГ-аас өгсөн үнэлгээ
1.	Засгийн газрын хуралдаан зохион байгуулахад ашиглах хиймэл оюуны тоног төхөөрөмжийг худалдан авч, суурилуулж, хэрэглээнд нэвтрүүлэх (Зорилт 8)	1	1	80%	70%
2.	Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, УИХ-ын дарга нарын гадаад айлчлал, ёслолын арга хэмжээний санхүүжилт, зардал бүртгэлийг хангах (Зорилт 12)	1	2	95%	92%
3.	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дотоод үйл ажиллагаа, техник, тоног төхөөрөмжийн шинэчлэл, дижитал шилжилт, иргэдийн өргөдөл, гомдол шийдвэрлэх (Зорилт 14)	1	3	90%	80%
4.	Төсвийн ерөнхийлөн захирагчдын төсөв төлөвлөлт, тайлагнал, санхүүжилт, аудит, шилэн данс хэрэгжүүлэх (Зорилт 15.1)	1	16	95%	93%
5.	Хөгжлийн болон стратегийн бодлогод нийцсэн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хяналт хэрэгжүүлэх (Зорилт 15.2)	1	5	90%	82%
6.	Өмч хөрөнгийн бүртгэл, тооллого, ашиглалт, хамгаалалтыг холбогдох стандартад нийцүүлэн хэрэгжүүлэх (Зорилт 15.3)	1	4	86%	83%

7.	Хуулиар хүлээсэн нийтлэг үүрэг – архив, сургалт, ажлын хэсгийн гишүүн (Бусад)	1	3	96%	100%
Дундаж ерөнхий үнэлгээ		7	34	91%	89%

Хүснэгт-2

ҮНЭЛГЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ					
Газар, хэлтэс	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	85 буюу түүнээс дээш хувь бол "бүрэн хангалттай" (арга хэмжээ оновчтой тодорхойлогдсон, зорилтот түвшиндээ хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан, эсхүл шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, үр дүн гарч эхэлсэн)	70-85 хүртэл хувь бол "хангалттай" (шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулах)	70 хүртэл хувь бол "хангалтгүй" (удирдлага, зохион байгуулалт хангалтгүй, төсөв хөрөнгийг үр дүнтэй зарцуулж чадаагүй нь баримтаар нотолгоотой.)
СХОГ	7	34	21	13	0

ДҮГНЭЛТ

Санхүү, хөрөнгө оруулалтын газраас 2026 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн тайланг 91 хувиар үнэлж ирүүлснийг хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж 89 хувиар үнэлэв

Гүйцэтгэлийн тайлангаас зарим арга хэмжээний гүйцэтгэл бүрэн хангагдаагүй, тайлагнал дутуу, шалгуур үзүүлэлтэд хүрээгүй буюу мэдээлэл дутуу байсан тул үнэлгээг бууруулж тооцсон. Санхүү, хөрөнгө оруулалтын газар нь 2026 оны эхний хагас жилд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хангалттай хэмжээнд хэрэгжүүлэн ажилласан байна.

Санхүү, хөрөнгө оруулалтын газрын 2026 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний үр дүнд хүрсэн ажлаас дурдвал:

- Төсвийн ерөнхийлөн захирагчдын 4 Төсвийн ерөнхийлөн захирагч, 6 Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлан тэнцлийг хуулийн хугацаанд гаргаж, Үндэсний аудитын газраар аудит хийлгүүлэн Сангийн яаманд хүргүүлсэн.
- 1585 ш төлбөрийн даалгавар, 261 хүний томилолт тооцоо, 248 хүний цалин хөлсийг хуулийн хугацаанд гүйцэтгэсэн.
- Нийт 14,700.0 сая төгрөгийн 12 тендер зохион байгуулагдаж, тоног төхөөрөмж хүлээн авсан. Төрийн ёслолын 26 арга хэмжээ (зорилтот 18-аас давж) зохиогдсон.
- Архив, хөрөнгийн бүртгэл, сургалтын зорилт бүрэн биелэгдсэн.

Санхүү, хөрөнгө оруулалтын газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнөөс анхаарах шаардлагатай ажлаас дурдвал:

- Иргэн, байгууллагын өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хувь 84.1%-д хүрсэн нь зорилтот 100%-аас 15.9 нэгж хувиар хоцорч байна. 36 хоцорсон, 27 хяналтад байгаа албан бичиг дараагийн хагас жилд нэн тэргүүнд шийдвэрлэх шаардлагатай.
- ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд "Хязгаарлалттай" санал авсан нь санхүүгийн тайлагналын чанар, баримт бичгийн бүрдэлд анхаарал хандуулах шаардлагатайг харуулж байна.
- 2027 оны УТХО-ын PIMIS-д оруулах ажил хагас жилийн хугацаанд дуусаагүй нь хэрэгжилтийн хоцрогдолд тооцогдох тул дараагийн улиралд даруй гүйцэтгэх шаардлагатай.

ЗӨВЛӨМЖ

- Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хувийг зорилтот 100%-д хүргэхийн тулд хоцорсон 36 албан бичгийг шийдвэрлэж, дотоод хяналтын механизмыг сайжруулах.
- Санхүүгийн тайлагналд "Хязгаарлалттай" санал авч байгааг арилгах зорилгоор аудитын зөвлөмжийн биелэлтийн хяналтыг эрчимжүүлэх.
- Гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилтын биелэлтийг хангахад чиглэсэн арга хэмжээг нэгтгэн оновчтой тодорхойлж, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинтэй уялдуулан нотолгоо баримттай тайлагнах.
- Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүгнэлт, зөвлөмжийн дагуу зорилтот түвшинд хүрээгүй арга хэмжээг үлдсэн хагас жилийн хугацаанд эрчимжүүлэн ажиллах.

ХЯНАСАН:



ДЭД ДАРГА С.БАТБОЛД

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:



ЗАСГИЙН ГАЗРЫН РЕФЕРЕНТ
Б.ОРГИЛ

Хавсралт

Хүснэгт-3

САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН 2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ДҮН /ЗААЛТ БҮРЭЭР/				
Арга хэмжээний д/д	Арга хэмжээний дугаар	Өөрсдийн өгсөн үнэлгээ	ХШҮ хийсэн үнэлгээ	Үнэлгээний тайлбар
ЗОРИЛГО 4. САЛБАР БОЛОН ОРОН НУТГИЙН ТҮВШИНД БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫГ ШИНЭ ТҮВШИНД ХҮРГЭНЭ.				
Зорилт 8. Засгийн газрын хуралдаанд хиймэл оюуны тоног төхөөрөмж нэвтрүүлэх				
1	8.8.1	80	70	Тендер шалгаруулалт хагас жилийн эцэст (2026.06.19) нээсэн бөгөөд бодит тоног төхөөрөмж суурилуулагдаагүй байна. Програм хангамжийн нэг жилийн эрх, сургалтын төлбөр шийдвэрлэгдсэн нь мэдэгдэхүйц ахиц боловч зорилтот хэрэгжилт дутуу байгааг харгалзан бууруулав.
ЗОРИЛГО 4. НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭ – ЁСЛОЛ, АЙЛЧЛАЛ				
Зорилт 12. Ёслол хүндэтгэлийн арга хэмжээ зохион байгуулах				
2	12.1.1	95	90	Ерөнхий сайд Г.Занданшатарын Давосын айлчлалын зардал бүртгэгдсэн, 11 нэр бэлэг авалт хийгдсэн. Зорилтот 11 айлчлалд хүрсэн
3	12.2.1	95	95	26 ёслолын арга хэмжээ зохиогдсон (зорилтот 18-аас давсан), 52 гэрээ байгуулсан, аудитын зөвлөмжийн дагуу "Ёслолын бэлэг дурсгалын журам" боловсруулж байна.
ЗОРИЛГО 4. ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА, ТЕХНИК, ИРГЭДИЙН ХАНДАЛТ				
Зорилт 14. Техник, тоног төхөөрөмжийн шинэчлэл; дижитал шилжилт; өргөдөл, гомдол шийдвэрлэх				
4	14.3.1	90	85	14,700.0 сая төгрөгийн 12 тендер зохион байгуулагдаж, гэрээ байгуулж хүлээн авсан. Санхүүгийн тайлан тэнцэлд тусгах ажил дуусаагүй байна.
5	14.6.1	90	80	385 нэр төрлийн тоног төхөөрөмж хүлээн авч, бүртгэлд авахаар ажиллаж байна.
6	14.8.1	90	75	323 ирсэн АБ-ийн 227-д хариу бэлтгэснээс 191-ийг хугацаандаа шийдвэрлэж, 36 хугацаа хоцруулсан; 27 хяналтад байна. Шийдвэрлэлтийн хувь 84.1% — зорилтот 100%-аас 15.9 оноогоор доогуур байна.
ЗОРИЛГО 5. ОРЧИН ҮЕИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭ – САНХҮҮ, ТӨСӨВ				
Зорилт 15.1. Төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүү, тайлагнал, санхүүжилт				
7	15.1.1	100	100	1585 ш төлбөрийн даалгавар гүйцэтгэгдсэн.
8	15.1.2	100	100	261 хүнд томилолт олгосон, 74 тооцоо хийгдсэн.
9	15.1.3	95	90	Шинэ санхүүгийн програм (Unicus) нэвтрүүлэлт бүрэн дуусаагүй; хагас жилийн тайланд тулгах ажил явагдаж байна.
10	15.1.4	100	100	Гүйлгээ зохих журмаар хийгдсэн.

11	15.1.5	95	95	248 хүний цалин тогтмол тооцогдсон, цалин мэдээлэл цахимаар хүргэгдсэн.
12	15.1.6	80	80	Хэвийн
13	15.1.7	100	100	Хуваарь хугацаанд хүргэгдсэн.
14	15.1.8	100	80	Шадар сайд (ОББХ), Шадар сайд (ГХОХАА), ЗГХЭГ "Хязгаарлалттай" санал, дүгнэлт авсан нь санхүүгийн тайлагналын чанар хангалтгүй байгааг харуулж байна.
15	15.1.9	77.5	77.5	4 ТЕЗ-ийн аудитын санал "Хязгаарлалттай" — газрын өөрийн үнэлгээг баталж байна.
16	15.1.10	100	100	2027 оны хязгаарын санал хугацаанд хүргэгдсэн.
17	15.1.11	100	95	2027 оны нэгтгэсэн төсвийн хязгаар хугацаанд хүргэгдсэн, агуулгын чанар сайн.
18	15.1.12	100	100	54 Албан бичиг
19	15.1.13	100	100	ТЕЗ 4-ийн 36 сарын тайлан мэдээ гаргагдсан.
20	15.1.14	95	90	Үндэсний аудитын газарт төлөвлөгөө хүргэгдсэн, fas.audit.mn-д байршуулсан.
21	15.1.15	95	90	tender.gov.mn-д 281 мэдээлэл байршуулсан, хугацаанд нийцсэн.
22	15.1.16	100	95	Тооцоо нийлж, төлбөр шилжсэн. Утасны шилжилт зохион байгуулагдсан.
Зорилт 15.2. Хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хяналт				
23	15.2.1	95	90	GPS v4.0-д санал оруулсан боловч систем алдаатай байснаас болж албан бичгээр орлон хийгдсэн нь эрсдэл байна.
24	15.2.2	95	90	3 санал хүргүүлсэн, хугацаанд нийцсэн.
25	15.2.3	70	60	2027 оны PIMIS-д оруулах ажил 07.20 хүртэл үргэлжлэх, хагас жилийн дотор дуусаагүй байна.
26	15.2.4	90	85	18-аас 13 төслийн гэрээ байгуулагдсан (72%).
27	15.2.5	100	85	Тайланг 07.15-нд хүлээн авна гэсэн нь хагас жилийн хугацаанд дуусаагүйг харуулна.
Зорилт 15.3. Өмч хөрөнгийн бүртгэл, тооллого				
28	15.3.1	85	80	umch.gov.mn системд 6 байгууллагын хөрөнгө оруулагдсан. Тооллого дуусаагүй байна.
29	15.3.2	90	90	Карт шинэчлэгдсэн.
30	15.3.3	85	75	Тооллогын комисс байгуулагдсан боловч тооллого хагас жилд дуусаагүй. Үр дүн тайлан тэнцэлд тусгагдаагүй.
31	15.3.4	85	85	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэрийн дагуу хэрэгжүүлсэн.
БУСАД. ХУУЛИАР ХҮЛЭЭСЭН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ				
Бусад				
32	1	100	100	Сайдын 3 тушаалаар ажлын хэсэгт орж ажилласан.

33	2	90	100	320 боть баримт архивт хүлээлгэн өгсөн (зорилтот 198-аас давсан).
34	3	100	100	31 хүн 7 чиглэлийн сургалтад хамрагдсан.
Нийт дундаж үнэлгээ		91%	89%	Дундаж үнэлгээ 2%-иар буурсан